



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар A/1115

Улаанбаатар хот

**Г Түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагааг
эрхлэх байршил батлах тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 25 дугаар зүйлийн 25.1.6, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд түргэн үйлчилгээний цэг байршуулах болон хориглох байршлыг 1 дүгээр, түргэн үйлчилгээний цэгээр ашиглуулах дулаан автобусны буудлын байршлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Б.Лхагва-Эрдэнэ)-нд, хяналт тавих ажлыг Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газар (Г.Байдраг)-т, Сонгинохайрхан дүүргийн Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ (Х.Нэмэхбаяр)-т, Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс (С.Нямдорж)-т, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Сугар)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны "Нийтийн эзэмшлийн гудамж талбайд зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ эрхлэхийг хязгаарлах тухай" А/198 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТТӨР

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
А/115 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ЗӨВШӨӨРӨХ, ХОРИГЛОХ
БАЙРШЛУУДЫН ЖАГСААЛТ

1.Түргэн үйлчилгээний цэгийн зөвшөөрөх байршлууд:

Д/д	Хороо	Гудамж замын нэр	Байршил	Байршуулах ТҮЦ-ны тоо
1	2	3	4	5
1	34	Найрамдлын зам	Буман өлзий хороолол Улаан дэлгүүр автобусны буудал дээр хойшоо чиглэлд	2
2	34	Найрамдлын зам	Орбит 2 автобусны буудал дээр урагшаа чиглэлд	2
3	20	Найрамдлын зам	Хүнс трейд автобусны буудал дээр төврүү чиглэлд	2
4	20	Сонсголонгийн зам	Монос эмийн үйлдвэр автобусны буудал дээр	1
5	20	Сонсголонгийн зам	Автобус 2 автобусны буудал /ЗООНОЗ/	2
6	20	Сонсголонгийн зам	Дэвшил компани автобусны буудал дээр	2
7	20	Сонсголонгийн зам	Сонсголон ШТС автобусны буудал дээр /013-р цэргийн анги/	2
8	20	Сонсголонгийн зам	Монгол цахилгаан утас автобусны буудал дээр	2
9	20	Сонсголонгийн зам	Бетон зуурмаг автобусны буудал дээр	2
10	20	Сонсголонгийн зам	Сонсголон завсар автобусны буудал дээр	1
11	32	Товчооны зам	Салдаг уулзварын баруун талд	2
12	32	Эмээлтийн зам	Эмээлтэд	2
13	24	Баруун салааны зам	Баруун салаа Бумбатын рашаан орчим	2
15	42	Зүүн салааны зам	Зүүн салааны эцсийн буудал	2
Нийт				26

2.Хориглох байршлууд:

- 2.1.Москвагийн гудамж;
- 2.2.Үйлдвэрчний эвлэлийн гудамж;
- 2.3.Толгойтын гудамж;
- 2.4.Толгойтын зам, Найрамдлын замын уулзвараас Москвагийн гудамж хүртэл;
- 2.5.Өнөр хорооллын гудамж (Нэгдүгээр хорооллын арын зам);
- 2.6.Баянхошууны гудамж;
- 2.7.Хувьсгалын гудамж;
- 2.8.Баруун салааны гудамж;
- 2.9.Зүүн салааны гудамж;
- 2.10.Байшин хороолол дунд;
- 2.11.Гэр хорооллын дунд;
- 2.12.Нийтийн эзэмшлийн зам талбай;

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 02 дугаар сарын 16 ны өдрийн
А/115 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛУУЛАХ
ДУЛААН АВТОБУСНЫ БУУДЛЫН БАЙРШЛУУДЫН ЖАЛГААЛТ

Д/д	Хороо	Автобусны буудлын нэр, байршил	Талбайн хэмжээ м.кв
1	2	3	4
1	1	Өрхийн эмнэлгийн буудал /баруун/	2.50*1.20=3
2	2	42-ын буудал /урд/	2.50*1.20=3
3	8	Баянхошууны тойрог /зүүн/	2.50*1.20=3
4	11	Хөтөл /баруун/	2.50*1.20=3
5	18	Таван шар /хойд/	2.50*1.20=3
6	19	Авто сургууль /урд/	2.50*1.20=3
7	20	Нефть /хойд/	2.50*1.20=3
8	27	Дүүргийн буудал /баруун/	2.50*1.20=3
9	27	Авто сургуулийн буудал /хойд/	2.50*1.20=3
10	33	122-р Сургууль /баруун/	2.50*1.20=3
11	22	Тойргийн буудал /урд/	2.50*1.20=3
12	32	Баруун түрүү Завсар-1 /баруун/	2.50*1.20=3
13	33	Тахилтын эцсийн буудал	2.50*1.20=3
14	34	Улаан дэлгүүр /баруун/	2.50*1.20=3
15	9	Баянхошууны эцэс	2.50*1.20=3
16	22	Хорооны буудал /урд/	2.50*1.20=3
17	24	Баруун салааны хуучин эцэс /баруун/	2.50*1.20=3
18	25	Улаан дэлгүүрийн буудал /зүүн салааны хуучин эцсийн дээд, баруун/	2.50*1.20=3
19	36	Улаанчулуутын эцэс	2.50*1.20=3
Нийт			19